



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/159

Мандалговь

Газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өлзийт сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байршилтай "Мандал тулга" ХХК (РД:6363415)-ийн аялал жуулчлалын зориулалттай 85944м² (8,59га) газрын газар эзэмших эрхийг хүчингүй болгож нийтийн эдэлбэрийн газар болгосугай.
2. Дээрх аж ахуйн нэгжтэй байгуулсан газар эзэмших гэрээг цуцалж, гэрчилгээг хүчингүй болгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт үүрэг болгосугай.
3. Энэ захирамж гарсантай холбогдуулж Өлзийт сумын Засаг даргын 2022 оны А/159 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100659